МЭДЭЭ · 2023 оны 1-р сарын 9

АВЛИГА, АЛБАН ТУШААЛЫН 6 ХЭРЭГТ ЯЛЛАХ ДҮГНЭЛТ ҮЙЛДЭН ШҮҮХЭД ШИЛЖҮҮЛЭВ



Прокурорын байгууллага өнгөрсөн долоо хоногт буюу 2023 оны 1 дүгээр сарын 02-ноос 06-ны өдрүүдэд хэрэг бүртгэлтийн 30.244, мөрдөн байцаалтын 1403 хэрэгт хяналт тавьж ажиллав.

Хяналтын ажлын явцад мөрдөгч болон зөрчлийн хэрэг бүртгэх эрх бүхий албан тушаалтанд тодорхой ажиллагаа гүйцэтгүүлэхээр 348 даалгавар бичгээр өгч, гэмт хэрэг, зөрчил гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар байгууллага, албан тушаалтанд 2 мэдэгдэл хүргүүллээ.

Түүнчлэн Эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 111, Өмчлөх эрхийн эсрэг 74, Амьд явах эрхийн эсрэг 15, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 13, Хүрээлэн байгаа орчны эсрэг 9, Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг 9, Авлига, албан тушаалын 6, нийт 237 хэргийг яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлж шийдвэрлэлээ. Тухайлбал:

- Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Хурх тосгоны захирагчаар ажиллаж байсан Э, тосгоны захирагчийн ажлын албаны дарга Ц нар нь албан тушаалтны эрх мэдлээ хэтрүүлэн, бусдад давуу байдал бий болгосон гэх хэрэгт 2002 оны Эрүүгийн хуулийн 264 дүгээр зүйлийн 264.2-т /Төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх/ зааснаар яллах дүгнэлт үйлдэн Хэнтий аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд,

- Говьсүмбэр аймгийн Баянтал сумын Засаг даргаар ажиллаж байсан М, Тамгын газрын дарга Г нар нь эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, бусдад давуу байдал бий болгосон гэх хэрэгт Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1-т /Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/ зааснаар яллах дүгнэлт үйлдэн Говьсүмбэр аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд,

- Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Оюутны хөгжил удирдлагын газрын арга зүйчээр ажиллаж байсан Т нь албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, тус сургуульд элсэх, анги шилжүүлэх гэсэн ашиг сонирхол бүхий нэр бүхий иргэдээс хахууль авсан гэх хэрэгт Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйлийн зүйлийн 1, 3 /Хахууль авах/, 22.5 дугаар зүйлийн 1-т /Хахууль өгөх/ зааснаар яллах дүгнэлт үйлдэн Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд тус тус шилжүүлсэн байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2087